

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Танилцуулга

2015

Монгол улсын хүнсний салбар нь дараах үндсэн салбаруудаас бүрднэ.

Сүүний үйлдвэрлэл

Сүү, цагаан идээ нь монголчуудын уламжлалт хүнсний нэг бөгөөд хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай шим тэжээл болох уураг, амин хүчил, тос, нүүрс ус болон амин дэи эрдэс бодисыгхамгийн зохистой харьцаагаар агуулдаг бүтээгдэхүүн юм.

Монголын хөдөө өж ахуйгаас жилд нийлүүлэх боломжит нийт сүүний нөөц 575,2 сая литр, үүнээс үнээний сүү 380,8 сая литр байна.

Махны үйлдвэрлэл

Монгол улс бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг тул улирлын шинж чанартай мах бэлтгэл хийгддэг онцлогтой. Улсын хэмжээнд жилд дунджаар 8.0 гаруй сая толгой мал хүнсэнд хэрэглэж, 200 орчим мян.тн мах үйлдвэрлэн, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг.

Гурилын үйлдвэрлэл

Монгол хүний хоол хүнсний хэрэглээнд гурил, гурилан бүтээгдэхүүн томоохон байр суурь эзэлдэг бөгөөд гурилын үндсэн түүний эд болох буудай нь стратегийн хүнсний бүтээгдэхүүний ангилалд багтдаг.

Исгэлтийн үйлдвэрлэл

Монголын исгэлтийн үйлдвэрлэлийн салбарт өндөр хэмийн боловсруулалттай, ариутган агаартай үл харьцах орчинд савлах “Tetrapack” технологи, нано шүүлтийн технологи, хяналтын автомат удирдлага зэрэг олон улсын стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтэрч, импорт орлох шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн олшрон, дотоодын болон олон улсын үзэсгэлэн яармагт амжилт гаргаж байна.

Хоол үйлдвэрлэл


Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар нь хүнсний бүтээгдэхүүн буюу “түүхий эд”-ийг үйлдвэрлэлийн явцад боловсруулалт хийж хэрэглэгчдэд шууд хүргэж байгаа /нэмүү өртөг бий болгож байгаа/ үйлдвэрлэлийн салбар юм.

Монгол улсын хоол үйлдвэрлэлтийн салбарт 9329 ажилчид 8700 гаруй хоол үйлдвэрлэлийн газарт ажиллаж байна. Эдгээрээс гадаад хөрөнгө оруулалттай 80 гаруй аж ахуйн нэгж ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн дотор “KFC”, “PIZZAHUT” гэх олон улсад нэр хүндтэй сүлжээ хоолны газрууд ажиллаж байна.

Хүнсний салбарын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэм. нэгж	2012	2013	2014
Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл				
Малын мах	т	13158.5	19759.0	15126
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	2222.7	2347.2	3388.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн				
Шингэн сүү	мян.л	25 120.3	26 607.4	28 311.3
Тараг	мян.л	7 804.6	8 803.5	7 093.2
Цөцгий, цөцгийн тос, аарц, бяслаг	т	1920.3	1332.6	1557.4
Гурил, гурилан бүтээгдэхүүн				
Гурил	т	114898.8	246512.2	239505.5
Гурилан бүтээгдэхүүн	т	44087.7	46721.5	53278.4
Цэвэр ус, ундааны үйлдвэрлэл				
Цэвэр ус	мян.л	35 930.5	47 360.4	52 119.0
Амтат ус, ундаа	мян.л	74 552.4	78 918.3	92 537.0
Жүүс	мян.л	66 689.2	84 426.6	80 178.3
Дүн	мян.л	177172.1	210705.3	224834.3

Сүүлийн 2 жилд улсын хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 20,4%, үр тарианы үйлдвэрлэл 31,8%, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 18,2%-иар өссөн байна. 2014 онд боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад мах 1,5 дахин, шингэн сүү 6,4 хувиар, цөцгий, цөцгийн тос 21,7 хувиар, ундаа, шүүс, савласан ус 10,8%-иар тус тус өссөн байна.



Яагаад Монгол, давуу тал

- Дэлхийн хоёр том зах зээлийн дунд орших газар зүйн өвөрмөц байршил - үйлдвэрлэл нийлүүлэх боломж.
- Ардын сонгон үржүүлгийн үр дүнд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийн бүтээгдэхүүн.
- Монгол улсын нийт ажиллагсдын 35 орчим хувь тухайн салбарт ажиллаж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааныхаа үндсэн эх булгийг бүрдүүлж байдаг.
- Малын тоо тогтмол өссөөр байна.
- Чацаргана гэх экологийн эрүүл мэндэд ач тустай шинэ бүтээгдэхүүн бүхий агуулдаг байгаль.

Боломжууд

- Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, орчин үеийн технологи бүхий хүнсний жижиг, дунд үйлдвэр барих, хөгжүүлэх.
- Үйлдвэрлэлийн шинэ технологи нэвтрүүлэх.
- Салбарын мэргэшсэн сургалт нэвтрүүлэх.

Төрөөс хүнсний үйлдвэр талаар баримтлах бодлого

Хүнсний үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний чанарыг сайжруулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах зорилт тавин ажиллаж байна.

Хүнсний тухай хууль болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг 2012 онд баталсан бөгөөд эдгээр хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2013-2014 онд 29 журам, заавар боловсруулж, 19 журмыг батлуулан хэрэгжүүлж байна.

Дээрх хуулинд үйлдвэрлэгч, импортлогч нь зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хангах, хувь хүн хүнс импортлохыг хориглох, шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлээс эргүүлэн татах, бүтээгдэхүүний гарал үүсэл, үл мөрийг мөшгин тогтоох зэрэг зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу тогтоож, малчны хот, тариан талбайгаас хэрэглэгчийн ширээ хүртэлх хүнсний сүлжээний бүх үе шатанд мөрдөж байна.

Сүүлийн жилүүдэд хүнсний бүтээгдэхүүний импортоос хараат байдлыг багасгах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний (мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны ус) нэр төрөл, тоо хэмжээг тогтоох, зөвшөөрөл олгох тарифын зохицуулалтыг хийж байна.

Холбоо барих

Баттөгс Анужин
Сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний
мэргэжилтэн
Хөрөнгө Оруулалтын Газар
15141 ЗГ-ын XI байр, Самбуугийн гудамж-11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс
Утас: 976-11320706
Факс: 976-324076
Цахим хаяг: anujin@investmongolia.com

Ашигтай холбоосууд

Хүнс, Хөдөө Аж Ахуйн яам
<http://www.mofa.gov.mn/new/>
Монголын Хөдөө Аж ахуйн Үндэсний Ассоциаци
Нийслэлийн Хөдөө Аж Ахуйн Ассоциаци